



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 45

Номгон

Орон нутгийн өмчид хөрөнгө бүртгэж,
эзэмшигч тогтоох тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, “в”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 49 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад оруулсан нийт 2,970,001,045.00 (хоёр тэрбум есөн зуун далан сая нэг мянга дөчин таван) төгрөгийн төсөвт өртөг бүхий бизнес инкубаторын зориулалт бүхий үл хөдлөх хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэсүгэй.

2. Гадна цахилгаан хангамжийн угсралтын ажил 62469236 (жаран хоёр сая дөрвөн зуун жаран есөн мянга хоёр зуун гучин зургаан) төгрөгийн өртөг бүхий дэд станцын эзэмшигчээр “Баянхонгор-Эрчим хүч” цахилгаан түгээх ХХК-ийг, хавсралтад заасан 7 нэрийн 2,907,531,809.00 төгрөгийн өртөг бүхий барилга угсралтын ажил болон нийтийн эзэмшлийн байгууламжийн эзэмшигчээр “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийг тус тус тогтоож, байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсүгэй.

3. Дээрх хөрөнгийг нэр төрөл, хэмжих нэгж, тоо хэмжээг нарийн гаргаж хөрөнгө тус бүрээр задалж бүртгэхийг “Баянхонгор-Эрчим хүч” ЦТ ХХК, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ний ерөнхий нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

4. Хөрөнгө хүлээн авч бүртгэх, хүлээлгэн өгөх комисс томилж, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт даалгасугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.


ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

D:/2018/Alban bichig/TH togtool-2018

0117363



Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар сарын
02-ны өдрийн 45 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧӨӨС ОРОН НУТГИЙН ӨМЧИД ШИЛЖИЖ ИРСЭН ХӨРӨНГИЙГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭЖ, ЭЗЭМШИГЧ ТОГТООСОН ЖАГСААЛТ

№	Хэрэгжүүлсэн төслийн нэр	Бүртгэлд тусгах дүн	Хөрөнгийн эх үүсвэр	Гүйцэтгэгч байгууллагын нэр	Улсын комисс хүлээн авсан тухай	Эзэмшигч байгууллага	Тайлбар
1	Барилга угсралтын ажил	2 312 179 049,00	ХХААХҮЯам	Брижд констракшн ХХК	18.04.05	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК	Хөрөнгийн нэр төрлөөр задалж бүртгэлд тусгах
2	Гадна дулаан, уурын зуухны угсралтын ажил	158 453 932,00	ХХААХҮЯам	Брижд констракшн ХХК	18.04.05	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК	Хөрөнгийн нэр төрлөөр задалж бүртгэлд тусгах
3	Гадна цэвэр ус хангамжийн угсралтын ажил	61 894 419,00	ХХААХҮЯам	Брижд констракшн ХХК	18.04.05	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК	Хөрөнгийн нэр төрлөөр задалж бүртгэлд тусгах
4	Гадна бохир ус хангамжийн угсралтын ажил	39 391 493,00	ХХААХҮЯам	Брижд констракшн ХХК	18.04.05	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК	Хөрөнгийн нэр төрлөөр задалж бүртгэлд тусгах
5	Гадна цахилгаан хангамжийн угсралтын ажил	62 469 236,00	ХХААХҮЯам	Брижд констракшн ХХК	18.04.05	Баянхонгор Эрчим хүч ЦТ ХХК	Хөрөнгийн нэр төрлөөр задалж бүртгэлд тусгах
6	Гадна хашааны ажил	112 238 256,00	ХХААХҮЯам	Брижд констракшн ХХК	18.04.05	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК	Хөрөнгийн нэр төрлөөр задалж бүртгэлд тусгах

7	Явган зам, ногоон байгууламж	70 546 979,00	ХХААХҮЯам	Брижд констракшн ХХК	18.04.05	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК	Хөрөнгийн нэр төрлөөр задалж бүртгэлд тусгах
8	Авто зам	152 827 681,00	ХХААХҮЯам	Брижд констракшн ХХК	18.04.05	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК	Хөрөнгийн нэр төрлөөр задалж бүртгэлд тусгах
	Нийт дүн	2 970 001 045,00					

оОо